17	Орон нутгийн судлах музей	ТШЗ	Хязгаарлалттай
18	Баянхутаг сумын хүүхдийн цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
19	Баянмөнх сумын Эрүүл мэндийн төв	ТШЗ	Хязгаарлалттай
20	Цэнхэрмандал сумын хүүхдийн цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
21	Батширээт сумын хүүхдийн цэцэрлэг	ТШЗ	Хязгаарлалттай
22	Хэнтий Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ	ТБОНӨҮГ	Хязгаарлалттай
23	Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ	ТБОНӨҮГ	Хязгаарлалттай
24	Монгол хатдын өргөө цогцолбор ОНӨААТҮГ	ТБОНӨҮГ	Хязгаарлалттай
25	Хэнтий Орон сууц ОНӨАТҮГ	ТБОНӨҮГ	Хязгаарлалттай
26	Дархан сумын тохижилт үйлчилгээ	ТБОНӨҮГ	Хязгаарлалттай
27	Батширээт сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалттай

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн, /ТЕЗ, ТТЗ, ТШЗ, ОНӨААН/ аудитаар нийт 25,539.9 сая төгрөгийн 441 алдаа, зөрчил илрүүлснээс 5,305.6 сая төгрөгийн 96 алдааг залруулж, 93.6 сая төгрөгийн зөрчилд 32 төлбөрийн акт тогтоож, 14,104.3 сая төгрөгийн зөрчилд 202 албан шаардлага, зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 6,035.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 111 зөвлөмж өгсөн.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 22 нэгтгэсэн тайлангаас "Зөрчилгүй" 21 дүгнэлт өгч, Батширээт сумын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 541.0 сая төгрөгийн 30 алдаа, зөрчил илрүүлснээс 5.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 47.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 488.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 25 зөвлөмж өглөө.

**Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

Харьяа төсвийн 159 байгууллагаас 27 байгууллагыг түүвэрт хамруулж, 132 дүгнэлт өгснөөс Зөрчилгүй 111, Хязгаарлалттай 21 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 17,008.6 сая төгрөгийн 342 алдаа, зөрчил илрүүлснээс 1,029.9 сая төгрөгийн 83 алдааг залруулж, 92.7 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 12,846.1 сая төгрөгийн зөрчилд 178 албан шаардлага, зөрчил гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 3,039.9 сая төгрөгийн зөрчилд 49 зөвлөмж хүргүүлсэн байна.

#### **ОНӨААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 16 аж ахуйн нэгж байгууллагаас 10 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 5, “Хязгаарлалттай” 5 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,930.8 сая төгрөгийн 38 алдаа, зөрчил илрүүлснээс 4,269.6 сая төгрөгийн 10 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 211.6 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага хүргүүлж, 448.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 15 зөвлөмж өгч, 1 зөрчилд хариуцлага тооцуулах санал хүргүүлээ.

#### **Орон нутгийн түсгэй сангийн санхүүгийн тайлангийн аудитаар:**

Харьяа 87 орон нутгийн сангаас 87 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар нийт 776.6 сая төгрөгийн 29 алдаа, зөрчил илрүүлснээс 1.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 566.7 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 207.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 17 зөвлөмж өглөө. Аудитаар илэрсэн зөрчлийг ТТЗ-ын аудитын тайланд тусгасан.

### **4.2 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт**

Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,282.9 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлснээс 432.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1,850.0 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

#### **4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:**

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүү илрээгүй тул аудитаар залруулга хийгдээгүй болно.

#### **4.2.2 ТЕЗ-д хүргүүлсэн албан шаардлага:**

Төсвийн ерөнхийлөн захирагчид 954.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 8 албан шаардлагыг хүргүүлээ. Үүнд:

1. Аймгийн Тагнуулын хэлтэст автомашин худалдан авахад зориулж 30 хувь болох 50.0 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.4 дэх "энэ тогтоол батлагдахаас өмнө /2021.02.17/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
2. Төрийн албан хаагчдын мэргэжлийн зэргийг нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор магистрын сургалтад 2022-2023 онд хамруулахад ШУТИС-ийн бизнесийн ахисан түвшний сургуультай гэрээ байгуулан 39.1 сая төгрөгийг шилжүүлж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",

- аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2021 оны 03 дугаар сарын 31-ний 24 дүгээр тогтоолоор орон нутагт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээг хангах зорилгоор баталсан “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам”-д нийцэхгүй байна.
3. Малыг эрсдэлээс хамгаалах сангийн бараа материалын данс дахь 78,513.4 мянган төгрөгийн өвс, тэжээлийн үлдэгдлийг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.
  4. Хэнтий аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Биндэр, Мөрөн, Цэнхэрмандал, Галшар, Баян-Овоо зэрэг 5 суманд 309.4 сая төгрөгийн автомашин, Галшар суманд 15.4 сая төгрөгийн тавилга худалдан авах ажлыг зохион байгуулж, 324.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.
  5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл арга хэмжээний 36.7 сая төгрөгийн хяналтын зардлыг бусад нэр заагдаагүй орлого дансанд төвлөрүүлсэн. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 -р тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5-д “Хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээг гүйцэтгэхдээ дансны хуулгыг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ.” гэж заасныг баримталж ажиллаагүй байна.
  6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн төсөл арга хэмжээний 21.4 сая төгрөгийн хяналтын зардлыг бусад нэр заагдаагүй орлого дансанд төвлөрүүлсэн. Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 -р тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" -ын 8.5-д “Хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээг гүйцэтгэхдээ дансны хуулгыг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ.” гэж заасныг баримталж ажиллаагүй байна.
  7. Аймгийн Тариаланг дэмжих сан дахь нөөцийн барааны үлдэгдлийг тоолж баталгаажуулан, үр дүнг шийдвэрлэх, Газар тариалан дэмжих сангийн 4.8 сая төгрөг, “Орон сууцны сан”-ийн 275.1 сая төгрөг, ЖДБДС-ийн 108.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах гэсэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
  8. Аймгийн ОНХС-аас 15.0 сая төгрөгөөр микро автобус худалдан авч Ахмадын хороонд буюу гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна” гэсэн заалтад нийцэхгүй байна.

#### **4.2.3 Төсвийг ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн зөвлөмж:**

Төсвийн ерөнхийлөн захирагчид 1,880.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 7 зөвлөмжийг хүргүүлж байна.

### **1. Төсвийн үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Орон нутгийн төсвийн 2020 оны татварын давсан орлогоос аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 31-ний 23 дугаар тогтоолоор Орон сууц ОНӨААТҮГ -ын дүрмийн санд 1,850.0 сая төгрөгийг төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн холбогдох заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон сууц ОНӨААТҮГ-т олгосон хөрөнгийг буцаан төсөвт төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллан, тухайн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах

### **2. Төсвийн үр ашиг, үр нөлөөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу аймгийн Улаан загалмайн хорооны үйл ажиллагааны зардалд төсвөөс дэмжлэг болгон 30.0 сая төгрөгийг олгосон боловч гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах

### **3. Орон нутгийн өмчит байгууллагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Баянмөнх, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Биндэр, дадал, Мөрөн, Баянхутаг, Батноров, Бор-Өндөр сумын Эмийн эргэлтийн сангуудын хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх ажил бүрэн хийгдээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын Эмийн эргэлтийн сангуудын Орон нутгийн өмчид төвлөрүүлэх хөрөнгийг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, Эмийн эргэлтийн сангуудыг данс бүртгэлээс хасах

### **4. Орон нутгийн өмчит байгууллагатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Өндөрхаан сүү ОНӨҮГ, Шинэ зууны залуу Хэнтий зэрэг байгууллагууд менежментийн гэрээ байгуулсан боловч он удаан жил үйл ажиллагаа явуулаагүй, дүгнэлт гаргасан 10 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс 7 байгууллага алдагдалтай ажилласан нь төсвийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж байна.

**Өгсөн зөвлөмж:** Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалт, төрөөс оруулсан өмч хөрөнгөөс хүртэх өгөөж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн орлого бүрдүүлэх зэрэгт хяналт тавьж, хууль тогтоомжийн дагуу бодлого арга зүйгээр ханган, холбогдох арга хэмжээг авах.

### **5. Орон нутгийн өмчтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Орон нутгийн төсөв, ОНХС-ийн хөрөнгөөр шаардлагагүй хөрөнгө бэлтгэн ОНӨҮГ болон төсөвт байгууллагуудын данс бүртгэлд орлогоор бүртгүүлэн тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй, ашиглалтгүй хөрөнгүүд бий болсон байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчид бүртгэлтэй ашиглалтгүй хөрөнгүүдийн судалгааг гаргаж, ашиглагч, эзэмшигч байгууллагыг зөв тодорхойлон, хөрөнгийн ашиглалт, бүртгэлд Орон нутгийн өмчийн газраас тавих хяналтыг сайжруулж ажиллах

#### **6. Байгаль хамгаалах сантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумдын Байгаль хамгаалах санд ойн болон ан амьтны нөөц ашигласны нөхөн төлбөр, торгууль, загас агнуурын зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, мод бэлтгэсний, хадлан авсны төлбөр, модны суулгацын зардал зэрэг орлого төвлөрүүлэн, сэлбэг, бараа материал, шатахуун, ажлын хувцас, бичгийн хэргийн материал, компьютер, мотоцикл худалдан авах, шагнал, сургалт зэрэг урсгал зардалд зарцуулсан нь холбогдох хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын засаг дарга нь Ашигт малтмалын тухай хуулийн 38.1-д заасан байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн мөнгийг тухайн дансанд төвлөрүүлж, хуулийн 38.3, 38.4-т заасны дагуу зарцуулах, өмнөх оны үлдэгдлээс хуульд нийцээгүй орлогын судалгааг гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
/сая төгрөгөөр/											
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Аймгийн ТЕЗ	7	2,282.9					2	432.9	5	1,850.0
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>2,282.9</b>					<b>2</b>	<b>432.9</b>	<b>5</b>	<b>1,850.0</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Аймгийн ТЕЗ										
	<b>Дүн</b>										
	<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>2,282.9</b>					<b>2</b>	<b>432.9</b>	<b>5</b>	<b>1,850.0</b>

6. Аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн асуудлын бүртгэлийн хариу



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Чингис хот, Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23119  
Утас/Факс: 70-56-21-51

Ауд. ат. д/б № 9/930


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Санхүүгийн нэгдсэн тайлангаар өгөгдсөн алдаа зөрчлийг цаашид гаргахгүй ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



231010300

## 7. Тайлан баталгаажуулсан тушаал



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 04 дугаар сарын 28

Дугаар А/08

Чингач хот

Аудитын тайлан  
баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5-р хавсралтын 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор / Н.Туяад/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР



ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР  
ХҮРГҮҮЛСЭН АЛБАН ШААРДЛАГА

№	Албан шаардлага хүргүүлсэн байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /мянган төгрөг/
1	Аймгийн ТЕЗ	199/A2370450 ХЭА-2022/189/НА-СТА-ТШЗ	21,400.0
2	Аймгийн ТЕЗ	200/A2370452 ХЭА-2022/190/НА-СТА-ТШЗ	324,800.0
3	Аймгийн ТЕЗ	233/A2370447 ХЭА-2022/188/НА-СТА-ТШЗ	50,000.0
4	Аймгийн ТЕЗ	234/A2370447 ХЭА-2022/188/НА-СТА-ТШЗ	39,100.0
5	Аймгийн ТЕЗ	235/A2370447 ХЭА-2022/188НА-СТА-ТШЗ	78,513.4
6	Аймгийн ТЕЗ	236/A2370450 ХЭА-2022/195/НА-СТА-ТШЗ	36,700.0
7	Аймгийн ТЕЗ	247/A2370447 ХЭА-2022/01/НА-СТА-ТЕЗ	388,500.0
8	Аймгийн ТЕЗ	248/A2370447 ХЭА-2022/01/НА-СТА-ТЕЗ	15,000.0
<b>НИЙТ ДҮН</b>			<b>954,013.4</b>

## 8. Хургуулсан албан шаардлага



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 200/А 2370452  
ХЭА-2022/190/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэртээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн төсөл арга хэмжээний 21.4 сая төгрөгийн хяналтын зардлыг бусад нэр заагдаагүй орлого дансанд төвлөрүүлсэн.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 -р тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" -ын 8.5-д "Хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээг гүйцэтгэхдээ дансны хуулгыг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ." гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.15-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ХУЛАНХАТАН

Д.ОЮУНТУЯА



Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390

023040800



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 23

Дугаар 199/АДЗ7045У  
ХЭА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Чингис хот

Г

Зөрчил арилгах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биндэр, Мөрөн, Цэнхэрмандал, Галшар, Баян-Овоо зэрэг 5 суманд 309.4 сая төгрөгийн автомашин, Галшар суманд 15.4 сая төгрөгийн тавилга худалдан авах ажлыг зохион байгуулж, 324.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А-95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг мөрддөггүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНГЭРЭЛ

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СНОД2021.07.02

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390

023040595

023040595



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 19

Дугаар 233/А2370447  
ХЭА 2022/188/НА-СТА-ТЭЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Тагнуулын хэлтэст автомашин худалдан авахад зориулж 30 хувь болох 50.0 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.4 дэх "энэ тогтоол батлагдахаас өмнө /2021.02.17/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагданаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохлон байгуулахгүй байх," гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав, СТСХ-ийн дарга С.Нямдаваа нарт даалгав.
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт өрүүлэх.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144297

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390

02374 92



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 19

Дугаар 235/А-2370447  
ХЭА 2022/188/НА-СТА-ТЭЗ

Чингис хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Малыг эрсдэлээс хамгаалах сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцэст бараа материалын данс дахь 78,513.4 мянган төгрөгийн өвс, тэжээлийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ. 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.-д "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Бараа материалын үлдэгдлийн тооллого хийгээгүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, төсвийн ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 19

Дугаар 236/А2370450  
ХЭА 2022/195/НА-СТА-ТНЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл зрга хэмжээний 36.7 сая төгрөгийн хяналтын зардлыг бусад нэр заагдаагүй орлого дансанд төвлөрүүлсэн.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 -р тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5-д "Хөрөнгө оруулалтын зардлын гүйлгээг гүйцэтгэхдээ дансны хуулгыг үндэслэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн нөхцөлд заасан барьцаа, техник хяналт болон гүйцэтгэгчийн холбогдох дансанд тус тус шилжүүлнэ." гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20 ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, ерөнхий нягтлан бодогч Д.Цэцэгсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Ц.НАРАНГЭРЭЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



02301 3115

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 25

Дугаар 234/АДЗТОННЗ  
ХЭА 2022/188/НА СТА ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчдын мэргэжлийн зэргийг нэмэгдүүлэх, үр чадварыг дээшлүүлэх зорилгоор магистрын сургалтад 2022-2023 онд хамруулахад ШУТИС-ийн бизнесийн ахисан түвшний сургуультай гэрээ байгуулан 39.1 сая төгрөгийг шилжүүлж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааны 2021 оны 03 дугаар сарын 31-ний 24 дүгээр тогтоолоор орон нутагт шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээг хангах зорилгоор баталсан "Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх журам"-д нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тошаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийн хэрэгжлэлийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа нарч даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СЮА0046 907-082

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 28

Дугаар 247/А2370447

Чингис хот

ХЭА-2022/01/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн аймгийн "Тариаланг дэмжих сан"-ийн 4.8 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдлийг тоолж баталгаажуулан, үр дүнг шийдвэрлэх, "Орон сууцны сан"-ийн 275.1 сая төгрөг, ЖДБДС-ийн 108.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэсэн заалтад нийцээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 195 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилладаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав, СТСХ-ийн дарга С.Нямдаваа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СЭА0046 9074982

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 28

Дугаар 248/АДЗТОННЗ  
ХЭА-2022/01/НА-СТА-ТЭЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ОНХС-аас 15.0 сая төгрөгөөр микро автобус худалдан авч Ахмадын хороонд буюу гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2.1 "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллагын өмчлөлд шилжүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх арга хэмжээ авах
2. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав, СТСХ-ийн дарга С.Нямдаваа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317144297  
СНОАДОНН 0024082  
Монгол Улс; Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 99775390